

Үндэсний аюулгүй байдлын бодлого, урт хугацааны хөтөлбөрийн эрх зүйд хийсэн шинжилгээ

Д.Батбаяр¹, Ш.Паламдорж²

¹*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Аюулгүй байдал судлалын төв*

²*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Цэргийн урлаг судлалын төв*

ABSTRACT

This article examines the current legal environment for ensuring national security in Mongolia and evaluates its capacity to address contemporary security challenges. While Mongolia has established a fundamental legal framework through the Constitution, the National Security Concept (2010), and related sectoral legislation, gaps remain in terms of coherence, implementation, and adaptability to emerging risks. The study highlights key shortcomings, including weak inter-sectoral coordination, insufficient mechanisms for monitoring and enforcement, and limited legal responses to new types of threats such as cyberattacks, climate change, and energy security. Furthermore, balancing national security with the protection of human rights remains a pressing issue within the legal system. Comparative perspectives from international practices, including the United States, Japan, and the United Nations, suggest that Mongolia needs to strengthen institutional accountability, improve the consistency of legal frameworks, and adopt more flexible, forward-looking legal instruments. The article concludes that sustainable national security requires a dynamic legal environment that not only safeguards sovereignty and stability but also aligns with human rights and international cooperation.

Keywords: *National security, legal environment, Mongolia, security policy, cyber security, human rights, international cooperation*

ОРШИЛ

Үндэсний аюулгүй байдал нь аливаа улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, төрийн байгууллын тогтвортой үйл ажиллагаа, иргэдийн эрх, эрх чөлөө, аюулгүй орших нөхцөлийг хангах үндсэн баталгаа болдог. Энэ нь улс орны эдийн засаг, нийгэм, улс төр, батлан хамгаалах болон гадаад харилцааны бодлого зэрэг үндэсний аюулгүй байдлыг хангах, түүнчлэн урт хугацаанд тогтвортой хөгжлийг хадгалах институтийн тогтолцоонд шууд хамаарал бүхий цогц үйл ажиллагааны нэгдэл байдаг. Иймээс үндэсний аюулгүй байдлын ойлголт нь зөвхөн батлан хамгаалах хүчин, хил хамгаалалтын хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд хүн, нийгэм, төрийн аюулгүй байдал, амьдралын хүрээний эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүч ба түүнийг хангамж, байгаль орчны хамгаалал, кибер

орчны аюулгүй байдал зэрэг олон талт бүрэлдэхүүн хэсгийг цогцоор нь авч үзэх учиртай.

Монгол Улсын хувьд ардчилал, хууль дээдлэх зарчимд тулгуурласан нийгмийн тогтолцоог төлөвшүүлэх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хамгаалах, бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулахын зэрэгцээ өөрийн аюулгүй байдлыг баталгаажуулах хэрэгцээ байнга тулгарч ирсэн. Төрөөс баталсан **“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (2010) болон “Алсын хараа–2050” (2020)** урт хугацааны хөгжлийн бодлого зэрэг баримт бичгүүд нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчны нэг үндэс болдог ч XXI зууны шинэ сорилт, эрсдэлтэй уялдуулан байнга шинэчлэн боловсронгуй болгох зайлшгүй шаардлага бий болдог.

Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд гарч буй өөрчлөлтүүд үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг илүү нарийн, иж бүрэн зохицуулалттай болгох шаардлагыг улам тодотгож байна. Нэгдүгээрт, **геополитикийн өрсөлдөөн** хурцадсан, бүс нутгийн томоохон гүрнүүдийн ашиг сонирхол Монгол Улсын эргэн тойронд огтлолцож буй нөхцөл байдал нь гадаад, дотоод аюулгүй байдлын сорилт, эрсдэлийг нэмэгдүүлж байна. Хоёрдугаарт, **шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил**, ялангуяа мэдээллийн технологи, хиймэл оюуны хэрэглээ өргөжихийн хэрээр кибер аюулгүй байдал үндэсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн болж байна. Гуравдугаарт, **байгаль орчны өөрчлөлт, уур амьсгалын нөлөө**, ус, эрчим хүч, хүнсний хангамжийн тасралтгүй байдал нь аюулгүй байдлын уламжлалт ойлголтыг өргөжүүлж, эрх зүйн зохицуулалтыг шинэ түвшинд хүргэхийг нөхцөлдүүлж байна.

Эдгээр сорилтуудын дунд Монгол Улс үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчноо зөвхөн батлан хамгаалах бодлогоор хязгаарлах бус, төрийн институтийн уялдаа холбоо, нийгмийн тогтвортой байдал, хүний эрх, эрх чөлөөтэй тэнцвэртэй байдлаар хөгжүүлэх нь чухал байна. Тухайлбал, **Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль** зэрэг бодлогын баримт бичгүүд хэрэгжиж байгаа боловч эрх зүйн хэрэгжилтийн түвшин, байгууллагуудын уялдаа сул байгаа нь тогтвортой байдлыг хангахад сөргөөр нөлөөлдөг.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин нь зөвхөн хууль тогтоомж батлах төдий бус, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, төрийн болон иргэний нийгмийн оролцоонд тулгуурлаж байж тогтвортой хөгжлийн суурь болж байна. Монгол Улсын хувьд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, шинэ сорилт, эрсдэлд нийцүүлэн хууль эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх хэрэгцээтэй тулгарч байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн тогтолцоо, орчны үнэлгээ

1. Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн суурь тогтолцоо

Монгол Улсад үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин нь Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгүүдэд тулгуурлаж

байна. 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь тусгаар тогтнол, төрийн байгууллын хэлбэр, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан суурь хэм хэмжээг тогтоож, аюулгүй байдлын эрх зүйн тогтолцооны үндэс болдог. Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт Монгол Улсын гадаад бодлогын үндсэн чиглэл, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах зарчим тодорхой заагдсан байдаг.

Үндсэн хуулийн үзэл санаанд тулгуурлан батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (2010) нь Монгол Улсын аюулгүй байдлыг хангах бодлого, стратегийн суурь баримт бичиг юм. Тус баримт бичигт үндэсний аюулгүй байдлыг төрийн, нийгмийн, хүний, эдийн засгийн, мэдээллийн, байгаль орчны, цэрэг-стратегийн гэх мэт олон чиглэлээр тодорхойлсон бөгөөд гадаад, дотоод хүчин зүйлээс хамаарсан аюул занал, эрсдэлийг иж бүрнээр авч үзжээ.

Үүнээс гадна, батлан хамгаалах, дотоодын аюулгүй байдлыг хангах чиглэлээр **Батлан хамгаалах тухай хууль (2016), Зэвсэгт хүчний тухай хууль (2016), Тагнуулын байгууллагын тухай хууль (2015), Онцгой байдлын тухай хууль (2017), Гамшгаас хамгаалах тухай хууль (2017), Кибер аюулгүй байдлын тухай хууль (2022)** зэрэг салбарын хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр хууль тогтоомж нь төрийн институтын үйл ажиллагааг зохицуулж, аюулгүй байдлыг хангах салбар бүрд тодорхой зохицуулалт бий болгосон бөгөөд эдгээр нь Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн суурь тогтолцоог бүрдүүлж байна.

2. Эрх зүйн орчин, давуу тал, ач холбогдол:

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг судлан үзэж дараах давуу талуудыг дүгнэн тодорхойлов. **Нэгдүгээрт**, эрх зүйн суурь тогтолцоо бүрдсэн нь онцлох, өндөр ач холбогдолтой юм. Үндсэн хууль болон түүнээс урган гарсан хууль тогтоомжууд нь үндэсний аюулгүй байдлыг цогцоор нь авч үзэх эрх зүйн үндэс суурийг бүрдүүлж, төрийн аюулгүй байдлын бодлогын тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж байна. **Хоёрдугаарт**, Монгол Улс олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн аюулгүй байдлын орчноо бүрдүүлсэн байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллага болон бүс нутгийн олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсноор аюулгүй байдлын хууль эрх зүйн орчныг олон улсын хэм хэмжээтэй уялдуулсан нь улс орны эрх зүйн тогтолцооны итгэлцэл, хамтын ажиллагааны чадавхыг нэмэгдүүлжээ. Жишээлбэл, цөмийн зэвсгээс ангид байх статусыг хуульчилсан нь бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. **Гуравдугаарт**, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь зөвхөн цэрэг-стратегийн чиглэлээр хязгаарлагдахгүй, харин хүний аюулгүй байдал, эдийн засаг, мэдээлэл, байгаль орчин зэрэг олон талт чиглэлийг хамарсан өргөн хүрээний зохицуулалтыг бий болгосон нь цогц, уялдаа холбоотой эрх зүйн орчин бүрдүүлэх давуу тал болж байна. **Дөрөвдүгээрт**, аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдаж байгаа нь онцгой ач холбогдолтой. “Алсын хараа–2050” баримт бичигт үндэсний аюулгүй байдлын тогтолцоог эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой нягт уялдуулан хөгжүүлэх чиг хандлага тодорхой тусгагдсан нь аюулгүй байдлын эрх зүйн орчныг эерэг талаас нь харуулж

байгаа бөгөөд энэ нь стратегийн хувьд ач холбогдол өндөртэй хөтөлбөр болохыг харуулж байна.

3. Эрх зүйг хэрэгжүүлэхэд тохиолдох хүндрэл, сорилт, эрсдэл:

Эрх зүйн хэрэгжилт, гарах үр нөлөөний хувьд тодорхой сул тал, хүндрэл байна¹. Үүнд:

1. Аюулгүй байдлын салбарын хууль тогтоомжууд хоорондоо уялдаа холбоо сул, зарим тохиолдолд хууль тогтоомжуудын давхцал их байгааг Монгол Улсын болон гаднын эрх зүйн шинжээчид дүгнэж байна². Жишээ нь, кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргийг ЗХЖШ, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг олон байгууллага хариуцдаг нь эрх зүйн зохицуулалтын давхардал, зарим хяналтын үйл ажиллагааг сулруулах, бодит эрсдэл учирсан тохиолдолд хариу арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэх эрсдэл үүсгэдэг.
2. Кибер, хиймэл оюуны хэрэглээ, эрчим хүчний сүлжээний доголдол, байгаль орчны доройтол зэрэгт чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалт бүрэн төлөвшөөгүй байна. Эдгээрт тохиолдох эрсдэлүүд нь зөвхөн Монгол Улсад бус, бүс нутгийн болон олон улсын түвшинд ч илэрч байгаа бөгөөд зарим улс орнууд үндэсний эрх зүйн тогтолцоогоо тасралтгүй шинэчлэх, төгөлдөржүүлэх замаар хариу арга хэмжээ авч байна.
3. Хэдийгээр Монгол Улсад үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжуудыг боловсруулан баталсан ч эдгээрийн хэрэгжилт, түүнчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хэрэгжилтийн тайланг тогтмол нийтлэх, дүн шинжилгээ хийх практик тогтсон уламжлал байхгүй, тогтворжоогүй сул хэвээр байна. Тухайлбал, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын хэрэгжилтийн явцыг тогтмол тайлагнах, дүн шинжилгээ хийх, түүнд үндэслэн цаашдын бодлого, арга хэмжээг тодорхойлох институт хоорондын уялдааг хангаж сайжруулах арга хэмжээ авдаггүй зэрэг нь зорилт, гарах үр дүн зэрэгт бодит үнэлэлт өгөх боломжгүй байна. Үүнээс үүдэн хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй үнэлэгдэж, бодит нөхцөл байдалтай уялдуулах, хэрэгцээнд тохирсон өөрчлөлт, шинэчлэлийг цаг тухайд нь хийх боломж хязгаарлагддаг. Мөн олон улсын жишигт түгээмэл хэрэглэгддэг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хяналт-шинжилгээний арга зүйг бүрэн нэвтрүүлээгүй байгаа нь бодлогын хэрэгжилтийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сулруулах нэг хүчин зүйл болж байна.
4. Хүний эрх, эрх чөлөөг хангах болон үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хоёрын хоорондын тэнцвэрийг хууль эрх зүйн түвшинд нарийвчлан тодорхойлоогүйгээс заримдаа эрх зүйн маргаантай нөхцөл байдал үүсдэг. Жишээлбэл, олон нийтийн цуглаан, жагсаал хийх эрх нь Үндсэн хуулиар баталгаажсан боловч уг үйл ажиллагааг “үндэсний аюулгүй байдалд

¹ Судалгаа.gov.mn / “21 төрийн захиргааны төв” төсөл (мэдээлэл, тайлан)

² UNODC — Country Review Report of Mongolia (UNCAC Cycle II, 2023)

нөлөөлж болзошгүй” гэх үндэслэлээр цагдаа, захиргааны байгууллагаас хориглох, хязгаарлах тохиолдол гарч ирдэг. Энэ нь иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн байгууллагуудын хооронд эрх зүйн маргаан, шүүхийн гомдол үүсгэх нөхцөл болж байна.

Мөн сүүлийн жилүүдэд цахим орчинд үг хэлэх, мэдээлэл түгээх эрхийг “кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал” гэсэн нэрийн дор хязгаарлах, тодорхой мэдээлэлд хандах эрхийг хаах явдал нэмэгдэж байгаа нь хүний эрх, эрх чөлөөний баталгаатай байдлыг сулруулах эрсдэлийг бий болгож байна.

Цаашид эрх зүйн зохицуулалт нарийвчлан тодорхойгүй хэвээр үргэлжилбэл, нэг талаас терроризм, кибер халдлага зэрэг шинэ төрлийн аюул заналтай тэмцэх нэрийн дор хүний эрх хязгаарлагдах; нөгөө талаас хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурласан зохицуулалт хангалтгүй болсноор төрийн байгууллагууд аюулгүй байдлын орчинд үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломж хязгаарлагдах зөрчилдөөн үүсэх магадлал өндөр байна.

5. Уур амьсгалын өөрчлөлт, ус, хүнсний хангамжийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал, институтийн хариуцлага тодорхойгүй байна. Тодруулбал, “Water Demand Management in Mongolia: Highlights of a National Dialogue on Water” (OECD, 2025) тайланд тэмдэглэснээр, Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт, хүдрийн усны давхарга багасах зэрэг хүчин зүйлээс болж усны эх үүсвэрт шахалт нэмэгдэж байгаа талаар судалгаанд дурдагдсан байдаг. Энэ нь үүссэн нөхцөл байдлыг зохицуулахад эрх зүйн болон институтийн зохицуулалт дутуу байгаа тухай дурдсан. Ус ашиглалт, зохицуулах байгууллагууд хоорондын зохицуулалт муу, усны бүртгэл, өгөгдөл цуглуулах систем бүрэн хөгжөөгүй зэрэг нь бодлого болон бодит хэрэгжилтийн хооронд зөрчил үүсгэж байна³.

4. Олон улсын туршлага, харьцуулалт

Олон улсын туршлагыг харьцуулан үзэхэд, үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин дараах чиглэлээр илүү боловсронгуй байгааг харж болно:

- АНУ-ын жишээ: Үндэсний аюулгүй байдлын стратеги, хууль эрх зүйн орчныг 4 жил тутам шинэчилж, Конгрессын сонголт, олон нийтийн хэлэлцүүлгээр баталгаажуулдаг байна. Энэ нь бодлогын хэрэгжилтийг илүү ил тод, хариуцлагатай болгодог байна.
- Европын холбоо: Кибер аюулгүй байдлын тухай NIS2 удирдамжийг нийт гишүүн орнуудад мөрдүүлэх замаар эрх зүйн орчныг стандартчилж, уялдаа холбоог хангаж ажилладаг байна.
- Япон, БНСУ-ын туршлага: Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (NSC)-ийг хуульчилж, төрийн институт хоорондын уялдааг эрх зүйн хүрээнд баталгаажуулсан байна.

Монгол Улсад эдгээр туршлагыг нутагшуулах боломжтой бөгөөд эрх зүйн шинэчлэл, хэрэгжилтийн ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр

³ Судалгаа.gov.mn / “21 төрийн захиргааны төв” төсөл (мэдээлэл, тайлан)

хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин суурь түвшинд бүрэн бүрдсэн хэдий ч, түүний хэрэгжилтийн үр нөлөө сул, шинэ сорилтуудад нийцсэн зохицуулалт хангалтгүй байгаа нь тодорхой хүндрэл учруулж байна. Эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо хууль тогтоомжуудын уялдаа холбоог бэхжүүлэх, хэрэгжилтийн хяналт-шинжилгээний тогтолцоог нэвтрүүлэх, кибер болон байгаль орчны шинэ заналхийлэлд чиглэсэн нарийвчилсан зохицуулалтыг бий болгох нь зайлшгүй байна. Түүнчлэн олон улсын туршлагаас суралцан, үндэсний онцлогт нийцүүлэн хууль эрх зүйн шинэчлэл хийх нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтвортой байдлыг хангах хамгийн чухал алхам болно.

Цаашдын хөгжлийн чиглэл нь үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг шинэчилж, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, төрийн институтын уялдаа холбоог бэхжүүлэх, шинэ төрлийн сорилтод нийцүүлсэн зохицуулалт бий болгох, хүний эрх ба аюулгүй байдлын тэнцвэрийг хангах, олон улсын туршлагыг нутагшуулахад чиглэнэ. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчны хөгжлийн стратегийн гол чиглэл болох юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин нь Үндсэн хууль болон түүнийг дагалдсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан бүрэлдэж, суурь түвшинд тогтвортой хөгжлийн баталгааг хангахуйц нөхцөл бүрдүүлсэн гэж үзэж болно. “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (2010), “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого, батлан хамгаалах, кибер аюулгүй байдал, гамшгаас хамгаалах зэрэг чиглэлийн хууль тогтоомжууд нь үндэсний аюулгүй байдлын олон талт ойлголтыг хамруулсан цогц зохицуулалт болж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин суурь түвшинд бүрдсэн боловч шинэ төрлийн сорилт, эрсдэлд нийцсэн уялдаа холбоотой, хэрэгжилт өндөртэй тогтолцоог боловсронгуй болгохыг нөхцөлдүүлж байна. Цаашид эрх зүйн шинэчлэл хийхдээ салбар хоорондын уялдааг бэхжүүлэх, хэрэгжилтийн хяналтыг сайжруулах, кибер, байгаль орчин, эрчим хүч зэрэг орчин цагийн гол сорилт, эрсдэлд чиглэсэн зохицуулалт бий болгох, хүний эрх ба аюулгүй байдлын харьцааг зөв тэнцвэржүүлэх нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтвортой байдлыг хангах гол нөхцөл болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Үндэсний хууль, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль. (1992/2019). Улаанбаатар: Улсын Их Хурал.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). Улаанбаатар: УАБЗ.
3. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. (2016). Улаанбаатар: Батлан

хамгаалах яам.

4. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа–2050”. (2020). Улаанбаатар: Засгийн газар.
5. Кибер аюулгүй байдлын тухай хууль. (2022). Улаанбаатар: Улсын Их Хурал.

Судалгааны бүтээл, өгүүлэл

1. Баабар. (2018). Үндэсний аюулгүй байдал ба Монголын орчин үеийн сорилт. Батлан хамгаалах аюулгүй байдлын судлал, 12(2), 45–60.
2. Мөнх-Очир, Д. (2020). Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт, сорилтууд. Монголын улс төр судлалын сэтгүүл, 8(1), 22–35.
3. Оюунболд, Г. (2022). Кибер аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын хөгжлийн асуудал. Хууль зүйн судлал, 14(3), 77–89.
4. Buzan, B., Wæver, O., & de Wilde, J. (1998). Security: A new framework for analysis. Lynne Rienner Publishers.
5. Schneckener, U. (2019). National security in the 21st century: Concepts and challenges. Journal of Security Studies, 15(4), 201–220.
6. Williams, P. D. (2018). Security studies: An introduction (3rd ed.). Routledge.

Олон улсын баримт бичиг

1. United Nations. (1945). Charter of the United Nations. New York: UN.
2. United Nations. (2015). Transforming our world: The 2030 agenda for sustainable development. New York: UN.
3. United States Government. (2022). National security strategy. Washington, DC: The White House.
4. Government of Japan. (2022). National security strategy. Tokyo: Cabinet Secretariat.